



**МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

20~~20~~ оны 11 сарын 23 өдөр

Дугаар 4652

Алтай хот

Г Ажлын хэсэг байгуулах тухай Т

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь хэсэг, Агаарын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1, 8.1.5 дахь заалт, Байгаль орчин, ногоон хөгжлийн сайдын 2014 оны А-181 дүгээр тушаалаар батлагдсан Агаарын бохирдлын эх үүсвэрийн улсын тоо бүртгэл явуулах журмыг тус тус үндэслэн **ЗАХИРАМЖЛАХ** нь:

1. Агаар бохирдуулах эх үүсвэрийн тоо бүртгэлийн ажлыг аймгийн хэмжээнд зохион байгуулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: -Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга

Нарийн бичгийн дарга: -Байгаль орчин, аялал жуулчлалын газрын дарга
Гишүүд: -Ус, цаг уур, орчны шинжилгээний төвийн дарга

-Авто тээврийн төвийн дарга
-Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн геологи, уул уурхай, байгаль орчин, аялал жуулчлалын хөгжлийн бодлого, төлөвлөлт хариуцсан мэргэжилтэн

-Мэргэжлийн хяналтын газрын байгаль орчны хяналтын улсын байцаагч

-Ус, цаг уур, орчны шинжилгээний төвийн Байгаль орчны шинжилгээний лабораторийн эрхлэгч

-Байгаль орчин, аялал жуулчлалын газрын орчны бохирдол, химийн бодис хариуцсан мэргэжилтэн

-Сумдын Засаг дарга

-Багийн Засаг дарга нар

-Сумдын байгаль орчны хяналтын улсын байцаагч

-Сумдын байгаль хамгаалагч

-Сумдын Цаг уурын өртөө, харуулын техникич

2. Агаар бохирдуулах эх үүсвэрийн тоо бүртгэлийн ажлыг холбогдох хууль, тогтоомжийн хүрээнд зохион байгуулж, үр дүнг 2021 оны 3 дугаар сарын 1-ний өдрийн дотор аймгийн Засаг даргын Зөвлөлийн хуралд танилцуулж ажиллахыг ажлын хэсгийн ахлагчид үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



О.АМГАЛАНБААТАР

0201001894